

## ГАРЧИГ

|           |   |           |
|-----------|---|-----------|
| <b>1.</b> | <b>ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>  | <b>2</b>  |
| 1.1       | ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....  | 8         |
| 1.2       | БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....                   | 10        |
| <b>2</b>  | <b>СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ.....</b>              | <b>11</b> |
| <b>3</b>  | <b>НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>   | <b>17</b> |
| <b>4</b>  | <b>ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>БИЕЛЭЛТ.....</b>                    | <b>20</b> |
| <b>5</b>  | <b>НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА<br/>ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b> | <b>22</b> |
| <b>6</b>  | <b>ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>           | <b>22</b> |
| <b>7</b>  | <b>ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>БИЕЛЭЛТ.....</b>                           | <b>23</b> |
| <b>8.</b> | <b>ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>БИЕЛЭЛТ.....</b>                             | <b>24</b> |
| <b>9</b>  | <b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН<br/>ХЭРЭГЖИЛТ.....</b>                             | <b>26</b> |
| <b>10</b> | <b>УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>БИЕЛЭЛТ.....</b>                         | <b>31</b> |
| <b>11</b> | <b>ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>БИЕЛЭЛТ.....</b>                        | <b>32</b> |
| <b>12</b> | <b>ДҮГНЭЛТ.....</b>   | <b>33</b> |
|           | <b>ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД.....</b>  | <b>35</b> |

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### *Компанийн танилцуулга:*

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

### *Төслийн зорилго:*

Энэхүү төсөл нь Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн эрдэс түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, импортыг орлох, ажлын байрыг нэмэгдүүлэх, уул уурхай, барилгын салбарын өсөн нэмэгдэж буй түүхий эдийн хэрэгцээг хангах юм.

### *Ордын газар зүйн байршил:*

Дэнжийн элс–1 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь Дэнжийн элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт, Улаанбаатар хотын төвөөс 60км–т, Налайх дүүргийн төвөөс 15 км–т Зуун модны элсний ордтой зэргэлдээ оршино.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар MV015573А. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон нийт талбайн хэмжээ 33.77 га болно.

Анх Дэнжийн элс-1 нэртэй талбайн 12748Х тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг “Ашигт малтмалын тухай” Монгол улсын хуулийн дагуу АМГТХЭГ-ын Кадастрын бүртгэлийн төвийн даргын 2007 оны 2213 тоот шийдвэрээр “Монголын Алт” ХХК-д “Гипфель” ХХК-ийн эзэмшиж байсан 9973Х тоот тусгай зөвшөөрлөөс хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн олгосон байна.


Хайгуулын ажлын дүнд "Дэнжийн элс"-ний ордын элсний бодитой (В) нөөцийг 221.327.36 куб.м, хайрганы бодитой нөөцийг (В) 5.675.06 куб метр, элсний (С) боломжтой

нөөцийг 316.684.07 куб. метр, хайрганы боломжтой нөөцийг 6.814.94 куб метр гэж тогтоосон. Ордын нийт элсний нөөц нь 538011.37 куб метр, хайрганы нийт нөөц 12.490.0 куб метр болж байна.

“Монголын Алт” ХХК-ийн “Дэнжийн элс”-ний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд уурхай нь зам тээвэр, цахилгаан, харилцаа холбооны бүхий л хэлбэрийг ашиглах боломжтой, дэд бүтцийн хөгжил сайтай бүсэд оршдог.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн газарзүйн солбилцол

1.  $107^{\circ} 29' 30.4''$   $47^{\circ} 47' 59.2''$
2.  $107^{\circ} 29' 00.4''$   $47^{\circ} 47' 59.2''$
3.  $107^{\circ} 29' 00.4''$   $47^{\circ} 48' 16.8''$
4.  $107^{\circ} 29' 30.4''$   $47^{\circ} 48' 16.8''$



*Зураг: 1 Лицензийн талбай*

#### **Цахилгаан хангамж:**

Уулын хэсгийн тоног төхөөрөмжүүдийн цахилгаан эрчим хүч, ажилчдын байрны гэрэлтүүлгийг 35 кВ-ын ЦДАШ, 35/04 кВ-ын дэд станцаас хангаж байна.

#### **Усан хангамж:**

Элсийг угааж боловсруулах төхөөрөмжид усан хангамж шаардлагатай ба уулын хэсгийн ажилчдад ундны усыг гүний худгийн уснаас хангаж байна. Тухайн оны ус

ашиглалтын дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, гэрээг холбогдох сав газартай байгуулж гэрээний үүргээ биелүүлэн ажилладаг. Уулын хэсгийн хувьд элс угаах төхөөрөмжийн усны хэрэглээг багасгах зорилгоор ашигласан усаа хуримтлуулж дахин элс угаахад ашиглаж байна

**Авто зам:**

Элсийг хатуу хучилттай улсын замаар тээвэрлэн үйлдвэр лүү хүргэнэ.

**Уурхайд ашиглагдах техник тоног төхөөрөмж**

Уурхайд Орос, Герман, Япон зэрэг улсад үйлдвэрлэгдсэн техник, тоног төхөөрөмжийг ашигладаг. 2022 онд ашигласан техник, тоног төхөөрөмжийг дараах хүснэгтэнд харуулав.

**Хүснэгт: 1 Уурхайд ашигласан техник, тоног төхөөрөмж**

| № | Техник, тоног төхөөрөмж    | Хүчин чадал       | Тоо хэмжээ /ш/ |
|---|----------------------------|-------------------|----------------|
| 1 | HITACHI -ZX360H экскаватор | 1,6               | 1              |
| 2 | XGMA 951H утгуурт ачигч    | 3м <sup>3</sup>   | 1              |
| 3 | TONLI                      | 25 тн             | 2              |
| 4 | TONLI                      | 32тн              | 1              |
| 5 | NORD BENZ- 25 тн           | 18 м <sup>3</sup> | 3              |
| 6 | PiCKUP үйлчилгээний машин  | 1 тн              | 1              |
| 7 | Нийт                       |                   | 9              |

**Зураг 2: Уурхайд ашиглагдаж буй техникүүд**



Hitachi -ZX360H экскаватор



XGMA 951H утгуурт ачигч



Tonly



Nord benz- 25 тн

### Элс ангилан ялгаж, угаах тоног төхөөрөмжийн ажиллагаа

Уулын хэсгээс автосамосвалаар бохир элс тээвэрлэж, элс хүлээн авах бункерт буулгаад, элс хүлээн авах бункерээс туузан дамжуургаар дамжин элс хуримтлуулах бункерт өгч хуримтлуулах бункерээс туузан дамжуургаар дамжин элс ангилан ялгах төхөөрөмжинд өгч элс хайргыг 5мм- ээс их, бага хэмжээтэй фракцаар ялгана.

Хаягдал хайрга буюу 5мм-с дээш хэмжээтэй хаягдал хайрга нь овоолгын туузан дамжуурга дамжин хаягдал хайрганы овоолго үүсгэнэ. Ангилсан элсийг (5мм-с бага хэмжээтэй) угаах төхөөрөмжид өгч холигч шурган голоор угааж элс хатаах төхөөрөмжөөс туузан дамжуургаар дамжин угаасан элсний овоолго үүсгэнэ.

### Хүснэгт: 2 Элс шигших болон угаах тоног төхөөрөмжүүд

| № | Техник, тоног төхөөрөмж         | Хүчин чадал | Тоо хэмжээ /ш/ |
|---|---------------------------------|-------------|----------------|
| 1 | Хүрдэт шигшүүр                  | 20 т/цаг    | 1              |
| 2 | Туузан конвейер                 | 130 т/цаг   | 3              |
| 3 | Элс угаах төхөөрөмж             | 200т/цаг    | 1              |
| 4 | Элс угаах төхөөрөмж XS1000*6000 | 140т/цаг    | 1              |

### Ажиллах хүчний мэдээлэл

Уурхайд 04 сарын 01-нээс 10-р сарын 1-ны хооронд элс угаах төхөөрөмж ажилласан ба элс шигших ажил явагдаж байна. 2022 онд Уулын хэсэг нь бүтэц, орон тоогоор нийт 36 ажилтантайгаар ажиллахаар төлөвлөгөөтэй байсан боловч 27 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Жилд календарийн 240 хоногоор ажилласан. Ажиллагсад Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажиллаж амарч байна.

*Хүснэгт: 3 Ажиллах хүнийн нөөцийн мэдээлэл*

| №  | Албан тушаал             | Орон тоо | Жилд ажиллах сар |
|----|--------------------------|----------|------------------|
| 1  | Уулын хэсгийн дарга      | 1        | 12               |
| 2  | Уулын инженер            | 1        | 10               |
| 3  | Уулын мастер             | 4        | 10               |
| 4  | Цахилгаан мастер         | 1        | 10               |
| 5  | Засварын мастер          | 1        | 10               |
| 6  | Екскаватор оператор      | 3        | 10               |
| 7  | Дугуйт ачигчийн оператор | 3        | 10               |
| 8  | Тээврийн жолооч          | 3        | 10               |
| 9  | Жолооч                   | 1        | 10               |
| 10 | Тогооч/туслах ажилчин    | 2        | 10               |
| 11 | Шигшүүрийн оператор      | 9        | 12               |
| 12 | Харуул                   | 2        |                  |
|    | Нийт                     | 31       |                  |

**Уурхайн барилга байгууламж**

Ил уурхайн бүрэлдэхүүнд түүний үндсэн үйл ажиллагаатай шууд холбоотой дараах объектуудыг барьж байгуулсан. Үүнд:

- Элсний ил уурхай, шимт хөрсний овоолго, хөрсний овоолго
- Засварын газар, граш, 1-2
- Сэлбэг хэрэгсэлийн агуулах
- Захиргаа, ажилчдын түр амрах байр
- Ажилчдын шинэ хоолны газрын суурын ажил хийгдээд явж байна.

**Сэлбэг хэрэгсэлийн агуулах**

Сэлбэг хэрэгсэл болон материал хадгалах 2 агуулахтай ба тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги, сэлбэг хэрэгсэл зэргийг хадгалах 50х50 метрийн хэмжээтэй задгай талбай байгуулсан. Ил уурхайн болон бусад хэсгүүдэд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, машин техникийн шатах тослох материалыг Улаанбаатар дахь төв Засвар үйлчилгээний төвөөс хангадаг ба шатахууныг Евро блокны үйлдвэрт байрлах ШТС-аас зөөврийн шатахууны тэргээр хангаж байна.

**Захиргаа ба ажилчдын хооллох түр амрах байр**

Уулын хэсгийн бичиг хэрэг, харилцаа холбоог ашиглан ажлаа явуулах захиргааны



байр, үдийн хоол идэх, түр амрах зориулалтай ажилчдын байрыг тус тус барьж ашиглалтанд оруулан ажилчдын ажиллах нөхцөлийг хангаж байна.



*Зураг: 3,4 Ажилчдын хоолны газрын суурь тавигдаж байгаа нь*



*Зураг: 5,6 Засварын газар*



*Зураг:7 Ажилчдын түр амрах байр*



*Зураг: 8 Хооллох хэсэг*



*Зураг 9: Сэлбэгийн агуулах*



*Зураг: 10 35/04 шугамын дэд станц, Дизель генератор нэмэлтээр суурилуулж ашиглахаар ажиллаж байна*



## **1.1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

### **Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Уурхайлалтын үйл ажиллагааны явцад тоосжилт бий болж орчны агаарын чанар, хүмүүсийн эрүүл мэнд, орон нутгийн экосистемд сөргөөр нөлөөлөх.
- Салхины элэгдлээр хаягдал гадаад овоолго тоос босож, орчин тойрны агаар бохирдох, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх
- Тээврийн хэрэгслүүд замаас гарч зогсох, үйлчилгээ засвар хийх зэргээс тоосжилт үүсэх, агаар орчинд нөлөөлөх

### **Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Төсөл хэрэгжих хугацаанд шимт хөрсний удаан хугацааны хадгалалтаас өнгөн хөрсний шим тэжээлийн бодис алдагдах, ялзмагийн агууламж багасаж болзошгүй.
- Хөрсөн бүрхэвч дээр зузаан нарийн тоосоор хучигдсанаас болж ургамлын фотосинтезийн үйл ажиллагаа алдагдан улмаар хөрсөн бүрхэвч үржил шимээ алдана.
- Шатах тослох материалын асгаралт, нэвчилт түүнчлэн ахуйн хог хаягдал зэрэг нь богино болон удаан хугацаагаар хөрсний бохирдлыг үүсгэж болзошгүй.

### **Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Уурхайн дэд бүтцийн барилгын ажлын явцад гадаргын уст цэг болон, голын гулдрил, тослох материал, барилгын материалын хог хаягдлаар бохир зэрэг түр зуурын нөлөөлөлд өртөх
- Уурхайн ашиглалтын явцад болон дэд бүтцийн барилгын ажлын явцад хуурай сайруудыг бохирдуулах эрсдэл нэмэгдэх

### **Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл**

- Элс олборлох, ачих, тээвэрлэх үеийн байнгын тоосжилтоос ургамлын фотосинтезийн эрчим буурах
- Уурхайн үйл ажиллагаанаас нөлөөллийн улмаас бэлчээрийн ач холбогдол бүхий талбай доройтох хумигдах
- Уурхайн олборлолтоос нийт 33.77 га талбайн ургамалан нөмрөг шууд, шууд бус нөлөөллөөр устах
- Шатах тослох материал алдагдах асгарч нэвчих нь хөрсийг богино болон удаан

хугацаанд бохирдуулсанаас ургамалан нөмрөгт нөлөөлөх

- Уурхайн дуу чимээ, гэрэлтүүлэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс зэрлэг амьтад уурхайн орчмоос дайжна.
- Уурхайн нүх, ухаш, шуудуунд мал, амьтан орж үрэгдэж үхэж болзошгүй.
- Зам ашиглалтын явцад зарим нэг зүйлүүдийн хэвийн шилжилт хөдөлгөөн алдагдах

## **1.2 . БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

2022 онд Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах “МАК Евро блок үйлдвэр нь 250,000 м<sup>3</sup> блок үйлдвэрлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс үзвэл “Дэнжийн элс”-ний уулын хэсэг нь 55173.4 м<sup>3</sup> цэвэр элс олборлож боловсруулан Евро блок үйлдвэрт нийлүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан.

Ийнхүү дээр дурдсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННУ-ний зөвлөмжүүд дээр үндэслэн тодорхойлж тэдгээрээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгаж бууруулах арга замыг уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтаасан болно.

**Зорилго:** Уулын хэсгийн үйл ажиллагаанаас урган гарах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дагуу төлөвлөгөөт ажлуудыг авч хэрэгжүүлэн нөлөөллийг хамгийн бага төвшинд байлгахад оршино.

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Олон улсын байгаль орчны менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлэх
- Байгаль орчны хяналтаар илэрсэн эрсдэл, сөрөг нөлөөллийг цаг алдалгүй илрүүлж, арилгах бууруулах арга хэмжээг зохион байгуулах
- Уулын хэсгийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арчилгаа, тордлого сайжруулах, тогтмолжуулах
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах талаар заавар зааварчилгааг ажиллагсад сургалтыг хэлбэрээр өгөх.
- Дүүргийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах
- Хог хаягдлын менежментийг сайжруулах

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### *Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд*

Уурхайн үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу Дэнжийн элс-1 уулын хэсгийн дарга дотоод замын сүлжээг баталсан бөгөөд зөвхөн батлагдсан замаар үйл ажиллагаа явуулах зааварчилгааг нийт ажилчдад өдөр тутмын наряд дээр сануулан, уулын мастер тогтмол хяналт тавьж ажилладаг ба салхи шуурга, хуурайшилт ихтэй үе буюу 5-8 саруудад тоос шороо их байгаа зам талбай, дотоод тээвэр, овоолгуудын усалгааны хэмжээг нэмэгдүүлж, тухайн өдрийн цаг агаараас хамааран 32 тонны усалгааны машинаар тогтмол усалгаа хийж, агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллалаа.

Доорх хүснэгтэд зам талбайн тоосжилт бууруулахад ашигласан усны хэмжээ болон бусад мэдээллийг оруулав.

*Хүснэгт 4*

| Үзүүлэлт        | Хэмжих нэгж | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Нийт дүн |
|-----------------|-------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|--------|--------|--------|----------|
| Усны тонли      | рейс        | 0     | 0     | 0     | 0     | 1     | 4     | 2     | 2     | 2     | 2      | 0      | 0      | 13       |
| Усны хэмжээ     | м3          | 0     | 0     | 0     | 0     | 32    | 96    | 64    | 64    | 64    | 64     | 0      | 0      | 320      |
| Нийт зам талбай | км          | 0     | 0     | 0     | 0     | 4     | 6     | 6     | 6     | 4     | 6      | 0      | 0      | 32       |



*Зураг: 11 Усалгааны машин*

Үйл ажиллагааны явцад замын тоосжилтыг багасгахын тулд батлагдсан зам талбайгаар зөвшөөрөгдсөн хурдаар тээвэрлэлт хийхэд уулын мастерууд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.




*Зураг: 12,13 Зам усалгаа хийжэ буй байдал.*

### **ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД**

Хөрс хамгаалах, хөрсний бохирдлоос сэргийлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хөрс болон шимт хөрсний хуулалт хадгалалтыг MNS 5916:2008 /Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт/ стандартын дагуу тусгай талбайд үүсгэн хадгалж байна. Хадгалалтанд хяналт тавьж шимт хөрсний овоолгонд мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн ба шимт хөрсний үндсэн үзүүлэлтүүдийг хангаж байна .



*Зураг: 14,15 Хөрс болон шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал*



Уулын хэсгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Шар хуайс, Улиас зэрэг 320 ширхэг 2 төрлийн суулгацийг суулгаж арчилгаа тордлогыг хийж гүйцэтгэсэн.



*Зураг 16,17: Ногоон байгууламж*



*Зураг:18,19 Тарилт ургалтын үйл явц*

**Хөрс хамгаалж, цөлжилтөөс сэргээлхийн тулд** эзэмшил талбайд олон салаа зам гаргахгүй байхад анхаарч, хяналт тавьж зөвхөн батлагдсан зам талбайгаар хурдаа тохируулан зорчих зааварчилгааг тогтмол өгч байна.

**Хөрсний бохирдлоос сэргийлэх ажлын хүрээнд:**

Хүнд машин механизмын засвар, үйлчилгээ, тээврийн хэрэгслүүдээс гарах ШТМ бохирдолыг бууруулах ажлын хүрээнд тусгайлан бэлтгэсэн талбайд засвар үйлчилгээг явуулж тос масло асгарахаас сэргийлэн зориулалтын сав ашиглан гүйцэтгэж байна. Мөн ШМТ хадгалах талбайг хатуу хучилттай болгож бохирдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна.



Хөрсөнд тос масло асгарсан тохиолдолд тухай бүр нь бохирдсон хөрсийг хусаж цэвэрлэж зориулалтын хөрс саармагжуулах талбайд саармагжуулж шинэ хөрсөөр хучилт хийж эзэмшил газрын хэмжээнд болон ойр орчимд бохирдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна.



*Зураг: 20,21: Хаягдал тос хадгалах талбай болон сав*



*Зураг: 22,23 Хөрс саармагжуулах талбай, Аюултай хог хаягдлаа өгөхдөө гэрээний дагуу дуудлага өгч нийлүүлж байна*

**Усны чанар, нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд**



**Зураг: 24 Баталгаажуулалтын гэрчилгээ**

**Зураг: 25 Усны хэрэглээний бүртгэл**

Уулын хэсгийн мастерууд өдөр, шөнийн ээлжид ажиллах ба ээлж хүлээлцэх бүрт гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг тогтмол шалгаж үзлэгийг хийж усны хэрэглээг тогтмол батлагдсан загварын дагуу бүртгэж хяналт тавьж ажиллаж байна. 2021 оны 12-р сард “Туулын сав газраас” цооног өрөмдөх зөвшөөрөл авч 1 худаг өрөмдсөн.


**Уурхайн 2022 онд ашигласан усны хэмжээ**

*Хүснэгт: 5*

|   | Эх үүсвэр   | Зориулалт         | Ус ашиглах хэмжээ |            |
|---|-------------|-------------------|-------------------|------------|
|   |             |                   | Усны дүгнэлтээр   | Тоолуураар |
| 1 | Гүний худаг | Үйлдвэрлэл        | 33,469.40         | 6,286      |
|   |             | Ногоон байгууламж | 6,960             | 959        |
|   |             | Унд ахуй          | 81,6              | 7,65       |
|   | Нийт        |                   | 40,511            | 7,253      |

2022 онд тоолуурын заалтаар нийт 7,253 м3 ус ашигласан.

График: 1



**АМЬТАН, УРГАМАЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД**

Зэрлэг амьтад болон иргэдийн малыг уурхайн ашиглалтын үйл ажиллагаанд өртөх, нүх, ухашинд унахаас сэргийлж тусгай зөвшөөрлийн талбайг тойруулан 2230 м урттай хашааг барьж байгуулсан ба энэхүү хашааны төв хаалган дээр байнгын 24 цагийн харуул хамгаалалт ажиллаж орчны хяналт тавьдаг.

Уулын хэсгийн ажилчдад ховор, нэн ховор амьтад тэдгээрийг бүртгэх, хамгаалах талаар сургалт орж байгаль орчны менежментийн системийн дагуу амьтны үзэгдлийг бүртгэж хяналт тавьж ажиллаж байна.



Зураг: 26 Сургалт

**СУРГАЛТЫН БҮРТГЭЛ**

Сургалтын сэдэв: Ховор, нэн ховор амьтад, Дунд зэрэм хүрээлэл  
Сургалт явуулагч: Сургалтын инструктор Б. Аринжаргал  
Байгаль орчны менежментийн Б. Дамбаа

Хугацаа: 1 цаг  
Огноо: 2021.10.06

| №  | Амьт нэр  | Амьтны тусламч | Хамгаалсан байр | Түрэмг үзэг |
|----|-----------|----------------|-----------------|-------------|
| 1  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 2  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 3  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 4  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 5  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 6  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 7  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 8  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 9  | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 10 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 11 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 12 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 13 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 14 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 15 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 16 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 17 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 18 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 19 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 20 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 21 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 22 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 23 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 24 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 25 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 26 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 27 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |
| 28 | С. Дорнод | С. Дорнод      | С. Дорнод       | С. Дорнод   |

Зураг: 27 Сургалтын бүртгэл



**Ургамлан нөмрөг**

Ургамалжилтын жагсаалт, зүйлийн бүрэлдэхүүн:

Хүснэгт: 6

| дд | Ургамлын нэр /латин/                        | Монгол нэр             |
|----|---|------------------------|
| 1  | <i>Cleistogenes squarrosa</i> /Trin/ Keng   | Дэрвээн хазаар өвс     |
| 2  | <i>Koeleria macrantha</i> /Ldb/ Schult      | Дааган сүүл            |
| 3  | <i>Poa attenuate</i> Trin                   | Сунагар биелэг өвс     |
| 4  | <i>Agropyron cristatum</i>                  | Саман ерхөг            |
| 5  | <i>Carex pediformis</i> C.A.Mey             | Зогдор улалж           |
| 6  | <i>Caragana pugmaea</i> /L/ DC              | Тарваган харгана       |
| 7  | <i>Kochia prostrata</i> /L/ Schrad          | Дэлхээ тогторгоно      |
| 8  | <i>Salsola collina</i>                      | Толгодын бударгана     |
| 9  | <i>Spiraea aguilegefolia</i> Pall           | Удвал навчит тавилгана |
| 10 | <i>Potentilla acaulis</i> L                 | Ишгүй гичгэнэ          |
| 11 | <i>Artemisia anethifolia</i> web.ex. Stechm | Божмог шарилж          |
| 12 | <i>Artemisia frigida</i> willd              | Агь                    |

Дээрх ургамалжилтын зүйлийн бүрдэл, эвшилд хяналт тавьж, бүртгэл, ажиглалтыг хийж ажиллаа. Дэнжийн элс-1 уулын хэсэг нь ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана.

**Ургамлын аймаг:** Хээрийн судалгааны үр дүнд судалгааны талбайд нийт 19 овог, 38 төрөлд хамаарагдах 46 зүйл гуурст дээд ургамал бүртгэгдэв. Үүнээс хамгийн их зүйлтэй овогт Нийлмэл цэцэгтэн-10, Буурцагтан-7, Үетэн-6, Сарнайтан-6; хамгийн олон зүйлтэй төрөлд Гичгэнэ-4, Харгана-2, Улалж-2, Шарилж-2, Банздоо-2 тус тус хамаарагдаж байна. Ургамлын аймгаар авч үзвэл нийт бүртгэгдсэн ургамлын нийлмэл цэцэгтэн-22%, үетэн-13%, буурцагтан-13%, сарнайтан-13%-ийг тус тус эзэлж байна.

**Ургамалжилтын судалгаа:** судалгаанаас үзэхэд энэхүү бүс нутагт 46 зүйл гуурст дээд ургамал тэмдэглэгдсэнээс олон наст өвслөг ургамал 89% (41 зүйл)-ийг эзэлж байв. Үлдсэн 11%-ийг сөөг ургамал (4% буюу 2 зүйл) болон заримдаг сөөгөнцөр ургамал (7% буюу 3 зүйл) бүрдүүлж байв. Судалгаа хийх үед тухайн нутаг хуурай гандуу байсны улмаас зарим ургамал гараагүй байсан. Ялангуяа цөөн наст өвслөг ургамалууд огт гараагүй байсан. Иймээс энэ тоо цаашид өсөх бүрэн боломжтой юм.




Зураг: 28, 29 Ургамлын мониторинг хийж байгаа үйл явц

### 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дэнжийн элс-1 уулын хэсэг нь 2022 онд 5100 мян м<sup>3</sup> талбайд шимт хөрсийг хуулан шимт хөрсний овоолго үүсгэсэн. Цаашид овоолгын өндрийг нэмэх учир энэ онд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй болно. Шимт хөрсний овоолго үүсгэх хадгалах үйл ажиллагааг ТЭЗҮ, БОННУ болон "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт" MNS 5916:2008 стандартын дагуу налуууг 18-22 градусын налууугаар хэвгийжүүлэн хадгалалтад хяналт тавьж , шимт хөрсний овоолгын өндөржилт 5 м , налуу, тогтвортой байдлыг хангаж ажиллаа. Мөн шимт хөрсний овоолгод мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэсэн ба шимт хөрсний үндсэн үзүүлэлтүүдийг хангаж нөхөн сэргээлтэд ашиглаж болохоор байна . */Шимт хөрсний шинжилгээний хариуг хүснэгт 7: харуулав/*

Зураг: 30 Уурхайн карьсар болон шимт хөрс овоолго



| №                                | Он         | Цэгийн нэр        | Sr            | Cd          | Pb            | Cu            | Zn            | Cr            |
|----------------------------------|------------|-------------------|---------------|-------------|---------------|---------------|---------------|---------------|
|                                  |            |                   | ppm           | ppm         | ppm           | ppm           | ppm           | ppm           |
| 1                                | 2022.04.07 | Шимт хөрс овоолго | 319.7         | илрээгүй    | 20.0          | 28.6          | 69.5          | илрээгүй      |
|                                  | 2022.08.17 |                   | 312.9         | 0.005       | 9.7           | 29.3          | 23.2          | 0.005         |
| 2                                | 2022.04.07 | Хог хаягдлын цэг  | 294.9         | 0.005       | 10            | 31.4          | 36.9          | 0.005         |
|                                  | 2022.08.17 |                   | 246           | 0.005       | 12            | 28.5          | 23.6          | 0.005         |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/  |            |                   | <b>150</b>    | <b>3,0</b>  | <b>100,0</b>  | <b>100,0</b>  | <b>300,0</b>  | <b>150,0</b>  |
| Хортой агууламж /MNS 5850:2019/  |            |                   | <b>1000,0</b> | <b>10,0</b> | <b>500,0</b>  | <b>400,0</b>  | <b>500,0</b>  | <b>600,0</b>  |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ |            |                   | <b>1800,0</b> | <b>20,0</b> | <b>1200,0</b> | <b>1500,0</b> | <b>1000,0</b> | <b>1000,0</b> |

*Хүснэгт: 7 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн*

Уурхайн хашааг тойрсон мод бутны тайралт, таналт, усалгаа арчилгааг тогтмол хийж гүйцэтгэлээ. 2013 оноос хойш нийт 3 төрлийн 690 ширхэг мод бут тарьсан ба ургалтын хувь 98% байна.

*Зураг: 31 Ногоон байгууламж*





*Зураг: 32 Ажлын байрны ойр орчим арчилгаа цэвэрлэгээ*



*Зураг: 33 Мод бутны тайралт, арчилгаа бордох*



### 3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийслэлийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих , гүйцэтгэх ажилд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төсвөлсөн мөнгөн дүнгээ / 8.000.000 төг / зарцуулан энэхүү бүтээн байгуулалтад оролцсон.

Мод тарьсан талбайн солбицол:

|    | Х           | Ү               |
|----|-------------|-----------------|
| 1. | 47 46 19.13 | 1. 106 42 55.58 |
| 2. | 47 46 16.25 | 2. 106 43 06.54 |
| 3. | 47 46 13.73 | 3. 106 43 04.77 |
| 4. | 47 46 13.89 | 4. 106 42 53.   |





**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Дэнжийн элс” -1 уулын хэсгийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан**



*Зураг: 34,35,36,37,38 Дүйцүүлэн хамгаалах ажлын явц*

Дүйцүүлэн хамгаалах ажил нь 10 сарын байдлаар дуусаагүй байгаа тул НБОГ-с акт тайлан ирээгүй байна.

#### **4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Төслийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн барилга байгууламж, үйлдвэрлэлийн төвлөрсөн хэсэгт хамаарч байгаа бөгөөд тус дүүргийн 5-р багийн Дэнжийн элсний уурхайн ойр орчимд нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдах айл өрх байхгүй юм.

#### **5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолт эхлэхээс өмнө 2012 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу ШУА-ийн Археологи ба Палеонтологийн төвөөр хайгуул, судалгааг хийлгэсэн бөгөөд тус хайгуул судалгаагаар археологи, палеонтологийн ямар нэгэн олдворт зүйл байхгүй гэсэн дүгнэлт гарсан.

Төслийн хамрах хүрээ нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн барилга байгууламж, үйлдвэрлэлийн төвлөрсөн хэсэгт хамаарч байгаа тул тусгайлан “Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө” боловсруулах шаардлагагүйг БОННУ-д зөвлөсөн байдаг.

Гэсэн хэдий ч уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдож болзошгүй тул үйл ажиллагааны явцад санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ын дагуу дагаж мөрдөн ажиллахаар төлөвлөсөн байдаг. Төлөвлөгөөт онд үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын олдвор илрээгүй болно.



## 7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Компанийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа “Хортой ба аюултай бодисын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллаж байна. Уулын хэсгийн үйл ажиллагаанд техникийн тос, маслыг Евро блокны үйлдвэр болон компанийн Улаанбаатар хот дахь Техник үйлчилгээний төвөөс олгодог бөгөөд бага хэмжээний тосолгооны материалуудыг уулын хэсгийн сэлбэг, хэрэгсэлийн агуулахад хадгалж ашиглаж байгаа бөгөөд ашиглалт хадгалалтанд уулын мастер тогмол хяналт тавьж ажилладаг.

Ахуйн хэрэгцээнд хэрэглэгдэх цэвэрлэгээний бодисуудыг аж ахуйн агуулахад хадгалж байна.

### Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлт

- ✓ Болзошгүй галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд нийт ажилчдад тогтмол зааварчилгаа өгч, хяналт тогтмол тавьж ажилласан. Гал унтраах багаж хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж зохих газруудад байрлуулсан.
- ✓ Галын аюулаас сэргийлэх дохио, санамж, тэмдгүүдийг шаардлагатай газарт нь байрлуулсан.

2022 оны 05, 09 дүгээр саруудад Гамшгаас хамгаалах, аврах тактикийн ажиллагаа, гал унтраах болон гамшигт нэрвэгдсэн ажилчдад эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх сургалтыг Төв Аймгийн Онцгой байдлын газрын аврах болон гал унтраах анги, Улаан Загалмайн нийгэмлэгийн нийт 25 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж үзүүлэх, дадлага олгох сургалтыг 2 цагийн хугацаатай орсон. 10:30 цагаас 12:00 цагийн хооронд. 2 цагийн хугацаатай орсон. 10:30 цагаас 12:00 цагийн хооронд болсон.



*/Зураг 39,40 Гамшгаас урьдчилан сэргийлэх, гал унтраах арга эзэмших анхны тусламж үзүүлэх танхимын , тактик сургалт/*

## Уурхайн догол, мөргөцөгт нуралт үүсэхээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлт

Нуралт үүсэхээс сэргийлж уурхайд ашиглалтын үед хөрс хуулалтыг орхигдуулж ашиглалтын системийн хэмжээсүүдийг мөрдөөгүйгээс доголын өндөр хэвийн хэмжээнээс өндөр болж нуралт үүсэх нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай.

Нуралт үүсэхээс урьдчилан сэргийлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

- Нуралт үүсэж болзошгүй газарт анхааруулах тэмдэг тавьсан.
- Хөрс хуулалт, элс олборлолтын зохистой харьцаанд хяналт тавьж ажилласан.
- Уурхайн ашиглалтын системийн хэмжээсүүдийг мөрдөж ажилласан.

## 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

